


Манай орны 9 дүгээр сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 9°C (48.2°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар $+12.1^{\circ}\text{C}$ (53.8°F) –аас $+19^{\circ}\text{C}$ (66.2°F), бусад нутгаар 9.1°C –аас $+12^{\circ}\text{C}$ (48.4°F –аас 53.6°F) дулаан байдаг байна.


Монгол орны хэмжээнд 9 дүгээр сард ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 9 хувь нь ордог. Тус сард төвийн болон нутгийн хойд хэсгээр 20.1-45 мм, бусад нутгаар 0.3-20 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 9 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны оронзайн тархалт


2025 оны 9 дүгээр сарын агаарын дундаж температур өмнөх жилээс 0.6°C -аар, ОЖД-аас 0.9°C -аар тус тус дулаан байсан ба 1940 оноос хойш тохиолдож байгаа 10 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нутгийн дийлэнх буюу 61.2% нь дунджийн орчим, 38.8% нь дунджаас $+1.0$ -ээс $+3.0^{\circ}\text{C}$ -аар дулаан байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 25.9 мм тунадас орсон нь өмнөх жилээс 19.3% -иар бага, ОЖД-аас 43%-иар ахиу буюу 1940 оноос хойш тохиолдож байгаа 17 дахь хур тунадас ихтэй сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 62% дунджаас ахиу, 8.5% нь дунджийн орчим, 29.5% нь дунджаас бага тунадас унасан байна.




Зураг 2. 2025 оны 9 дүгээр сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын оронзайн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 9 дүгээр сарын агаарын температурын хоногийн явцыг авч үзэхэд (Зураг 3) нийт нутгаар 1 болон 2 дугаар 10 хоногийн зарим хугацаанд агаарын температур ОЖД-аас -2.2°C -аас -7.6°C -аар хүйтэн байжээ. Харин үлдсэн хугацаанд, ялангуяа 3 дугаар 10 хоногийн дунд үеэс эхлэн нийт нутгаар агаарын температур ОЖД-аас $+2.5^{\circ}\text{C}$ -аас $+6.9^{\circ}\text{C}$ дулаан байсан байна. Хур тунадасны хувьд 2 дугаар 10 хоногийн дунд үе болон 3 дугаар 10 хоногийн эхээр нийт нутгаар харьцангуй ахиу тунадас орсон бол өмнө болон баруун бүс нутгуудад бага хур тунадас оржээ.



Зураг3. Хоногийн агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Тус сард агаарын температурын үнэмлэхүй их утга Өмнөговь аймгийн Ханбогд суманд 34.6°C , үнэмлэхүй бага утга Баянхонгор аймгийн Баянбулаг суманд -8.5°C хүрсэн. Хөрсний температурын үнэмлэхүй их утга Өмнөговь аймгийн Даланзадгадад 59°C , үнэмлэхүй бага утга Баянхонгор аймгийн Баянбулагт -12°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт хамгийн ихдээ Хэнтий аймгийн Дадал суманд 13-ны өдөр 51.2 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 951.4гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 767.6гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Ховд аймгийн Дунд-Ус суманд 34 м/с хүрсэн байна.



Зураг 4. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд